



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/546

Номгон

Малын тоо толгойн албан татвар болон Бэлчээрийг хариуцлагажуулах үлгэрчилсэн журам, бусад холбогдох хууль, журмын хэрэгжилтийг хангуулах ажлын хэсэг байгуулах тухай.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.17, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын тоо толгойн албан татвар болон Бэлчээрийг хариуцлагажуулах үлгэрчилсэн журам бусад холбогдох хууль, журмын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, малчид, иргэдээс гарсан гомдол, саналыг шийдвэрлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. Дээрх арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Гишүүд: Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Онцгой байдлын газрын дарга

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Татварын хэлтсийн дарга


Нарийн бичгийн дарга: Цагдаагийн газрын дарга

3. Шаардагдах зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын даргад зөвшөөрсүгэй.

4. Малын тоо толгойн албан татвар болон Бэлчээрийг хариуцлагажуулах үлгэрчилсэн журам бусад холбогдох хууль, журмын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, малчид, иргэдээс гарсан гомдол, саналыг шийдвэрлэх ажлыг чанартай зохион байгуулж тайлагнахыг Ажлын хэсэг (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642311413